



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2025/15/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дундговь аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: <a href="mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn">Munkhtogtokhr@audit.gov.mn</a> Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ Утас: 70592225 Цахим хаяг: <a href="mailto:Oyun-Erdenet@audit.gov.mn">Oyun-Erdenet@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: <a href="mailto:Batsaikhant@audit.gov.mn">Batsaikhant@audit.gov.mn</a> Аудитор: Д.Должинсүрэн Утас: 70593113 Цахим хаяг: <a href="mailto:Doljinsurend@audit.gov.mn">Doljinsurend@audit.gov.mn</a>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

<b>Нэг.</b> Хараат бус аудиторын дүгнэлт .....	3
.....	5
<b>Хоёр.</b> Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	6
<b>Гурав.</b> Аудитын илрүүлэлт .....	9
3.1. Албан шаардлага.....	9
3.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	9
<b>Дөрөв.</b> Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	11
<b>Тав.</b> Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл.....	12

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## Нэг.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайншагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
С.МӨНХБААТАР ТАНАА

2025.03.19 № 7Р  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар баяр наадмын зардлыг санхүүжилтийн жишиг дээд хэмжээнээс 40.0 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, санхүүгийн албан хаагчдын үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр 5.7 сая төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон.
- Хоршоо хөгжүүлэх сангаас 2024 онд 2.1 сая төгрөгийн үндсэн зээл, зээлийн хүүт төлөөгүй, хугацаа хэтрүүлснээс санд хохирол учруулсан.
- Мал хамгаалах сангийн насжилт өндөртэй 6.5 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2010 оны 271 дугаар тогтоолын "Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай (наадмын санхүүжилт)", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 8.3, Иргэний хуулийн 222.4, 222.5, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны

4825020268

А/361 дугаар тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.11, Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох, зээлдэгчтэй байгуулсан гэрээ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д, Төсвийн тухай хуулийн 6.4.8, 16.5.2 заалтуудтай нийцэхгүй байна.

Залруулагдаагүй алдаа нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 1.1 дахин их, зардлыг зориулалт бус зарцуулсан, санхүүгийн тайлан дахь насжилт өндөртэй авлага болон хоршоо хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүг барагдуулах арга хэмжээ аваагүй нь шинж чанар агуулгын хувьд материаллаг, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт, эрх үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 сарын сарын 01-ээр төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэн, сумын бүх төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг олгож эхэлсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос өссөн байна. Мөн орон нутагт тогтвор суурьшилтай 5 жил ажилласны тэтгэмжийг төрийн захиргааны албан хаагчдад олгож эхэлснээр 2 төсвийн байгууллагын 2024 онд 4 албан хаагч 28.8 сая төгрөгийн дэмжлэг авсан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 16 дугаар тогтоолын дагуу сумдын Эмийн эргэлтийн санг татан буулгах шийдвэр гарч, тус сумын Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 42.7 сая төгрөгийн хөрөнгө, 32.2 сая төгрөгийн өр төлбөрийг сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд нэгтгэн бүртгэсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд Азийн хөгжлийн банкны урт хугацаат зээлээр хэрэгжиж байгаа “Усан хангамж, ариутгах татуурга” байгууламжийн үндсэн хөрөнгийг 1,939,828.2 мянган төгрөгөөр нэмж, урт хугацаат өглөгөөр тайлагнасан нь хэрхэн төлөх нь тодорхойгүй тайлант үеийн өндөр үнэлэгдсэн эрсдэлтэй асуудал байлаа.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилт, 114 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 110 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 69.1 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль,

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг

буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	836,819.3	1,805,038.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	269,053.8	616,841.8
33	АВЛАГА	167,223.4	753,204.8
35	БАРАА МАТЕРИАЛ	240,342.1	274,792.3
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	160,200.0	160,200.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,544,386.2	5,003,489.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,544,386.2	5,003,489.8
39200	Биет хөрөнгө	3,483,502.3	4,942,411.2
39300	Биет бус хөрөнгө	60,884.0	61,078.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,381,205.5	6,808,528.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	49,856.9	2,020,703.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	49,856.9	80,875.1
41300	Өглөг	49,856.9	80,875.1
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	1,939,828.2
42200	Урт хугацаат зээл	0.0	1,939,828.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,331,348.6	4,787,825.4
51	Засгийн газрын хувь оролцоо	4,331,348.6	4,787,825.4
51100	Засгийн газрын оруулсан капитал	855,826.9	855,826.9
51200	Хуримтлагдсан үр дүн	2,810,783.4	3,267,260.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	664,738.4	664,738.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,381,205.5	6,808,528.7

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	4,017,242.7	4,540,241.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	643,500.5	1,305,414.6
110	Орлогын албан татвар	359,420.3	886,709.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	359,420.3	886,709.2
113	Хөрөнгийн албан татвар	193,166.6	218,353.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	90,913.6	200,351.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,611,722.8	801,151.6
120	Нийтлэг татварын бус орлого	1,611,722.8	801,151.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,762,019.4	2,433,675.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,091,934.9	2,999,039.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,091,934.9	2,999,039.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	273,634.1	2,949,292.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	523,723.8	857,891.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,088.1	106,603.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,764.9	769,180.4
2104	Хангамж, бараа материалын зардал	69,335.9	107,499.6
2105	Нормативт зардал	0.0	4,050.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,512.0	70,799.7

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2107	Томилолт, зочны зардал	19,088.4	23,542.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	624,709.5	222,129.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	639,471.8	787,596.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,240.5	49,746.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	1,925,307.9	1,541,202.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,305,834.0	1,161,725.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	619,473.8	379,476.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,690,919.7	3,690,919.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	21,028.9	21,028.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,711,948.6	3,711,948.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-73.8	-73.8
9	Тайлант үеийн үр дүн	619,473.8	619,473.8
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,331,348.6	4,331,348.6
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,331,348.6	4,331,348.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	77,000.0	77,000.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,408,348.6	4,408,348.6
19	Тайлант үеийн үр дүн	379,476.7	379,476.7
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,787,825.4	4,787,825.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,608,670.7	3,850,504.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	643,500.5	1,305,414.6
110	Орлогын албан татвар	359,420.3	886,709.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	359,420.3	886,709.2
113	Хөрөнгийн албан татвар	193,166.6	218,353.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	90,913.6	200,351.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,255.4	17,051.5
1181	Газрын төлбөр	84,658.1	58,020.2
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.0	125,280.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	205,363.6	111,414.2
120	Нийтлэг татварын бус орлого	205,363.6	111,414.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,759,806.6	2,433,675.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,708,297.4	2,519,565.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,708,297.4	2,519,565.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,691,269.8	2,469,818.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	518,063.8	860,158.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,120.5	106,571.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,764.9	768,856.4
2104	Хангамж, бараа материалын зардал	69,606.7	92,737.0
2105	Норматив зардал	2,650.0	5,070.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,512.0	71,143.6

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2107	Томилолт, зочны зардал	19,088.4	23,542.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	624,709.5	222,856.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	260,754.0	318,883.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,027.6	49,746.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	900,373.2	1,330,939.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,219,942.7	983,150.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,219,942.7	983,150.9
2200	Дотоод эх үүсвэрээр	1,219,942.7	983,150.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-1,219,942.7	-983,150.9
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-319,569.4	347,788.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	588,623.2	269,053.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	269,053.8	616,841.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,999,360.9	3,293,804.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,570,671.5	2,357,442.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,525,707.5	2,312,528.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	807,798.5	775,191.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,223.8	96,282.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	771,650.9	762,467.3
2104	Хангамж, бараа материалын зардал	79,621.7	80,336.3
2105	Норматив зардал	3,000.0	3,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	113,674.0	113,628.1
2107	Томилолт, зочны зардал	22,032.0	22,032.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	227,699.6	225,884.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	402,007.0	233,706.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,964.0	44,913.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,964.0	44,913.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,183,689.4	936,362.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	245,000.0	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,999,360.9	3,437,019.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	853,189.4	823,062.4
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,684,371.5	2,561,933.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	461,800.0	52,023.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	251,187.7
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	394,402.6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	208,911.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	208,911.6
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	204,078.5
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	84,966.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,289.3
2103	Байр ашиглалттай холбоотой	6,389.1
2104	Хангамж, бараа материал	12,400.7
2105	Норматив зардал	2,070.0
2107	Томилолт, зочны зардал	1,510.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,275.8
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	85,177.3

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

213	УРСГАЛ,ШИЛЖҮҮЛЭГ	4,833.1
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,833.1
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>208,911.6</b>
1311	Нэмэлт,санхүүжилтийн орлого	208,911.6

## Гурав. Аудитын илрүүлэлт

### 3.1 Сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитаар нийт 89,572.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 81,467.1 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 8,105.7 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлагыг хүргүүлжээ.

#### *Залруулсан алдаа:*

Аудитаар нийт 81,467.1 мянган төгрөгийн 2 алдаа<sup>1</sup> илрүүлж аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

- Мал хамгаалах сангийн хувь хүнээс авах 2,406.8 мянган төгрөгийн өвс тэжээлийн авлагыг дутуу тайлагнасан;
- Нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлогын эхний үлдэгдлийг 79,060.3 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан.

#### *Залруулаагүй алдаа:*

Аудитаар нийт 8,105.7 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 2 албан шаардлага хүргүүлсэн.

## 3.1. Албан шаардлага

**3.1.1** Мал хамгаалах сангийн 1,602.9 мянган төгрөгийн өвс тэжээлийг шийдвэргүй зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т /*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*/, мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т /*Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон Зөвлөл Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна* /заасныг;

**3.1.2** Аудитаар насжилт өндөртэй 6,502.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д /*өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх*/, Төсвийн тухай хуулийн 6.4.8-д /*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*/, 16.5.2-д /*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*/ заасныг тус тус зөрчсөн байна.

## 3.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

*Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:*

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1				1		
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	<b>НИЙТ</b>	6	1	5			1		

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт дүнгээр 1,008,567.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 761,292.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,062.3 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 242,583.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 14 албан шаардлага, 629.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүлээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 24.6 хувийг залруулагдаагүй, 75.4 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:**

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	2	40,300.0	2	40,300.0			2	40,300.0				
ХХС	1	2,109.1			1	2,109.1	1	2,109.1				
ОНХС	2	637,416.7	1	77,000.0	1	560,416.7	2	637,416.7				
МХС	1	2,406.8	1	2,406.8			1	2,406.8				
ОННТ	1	79,060.3			1	79,060.3	1	79,060.3				
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>761,292.9</b>	<b>4</b>	<b>119,707</b>	<b>3</b>	<b>641,586.1</b>	<b>7</b>	<b>761,292.9</b>	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :**

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	7	50,467.2	3	1,953.2	4	48,514.0						
ИТХ	1	629.0					1	629.0				
ХХС	1	2,109.1	1	2,109.1								
ОНХС	3	48,000.0			3	48,000.0						
МХС	2	8,105.7			2	8,105.7						
<b>Нийт дүн</b>	<b>14</b>	<b>109,311.0</b>	<b>4</b>	<b>4,062.3</b>	<b>9</b>	<b>104,619.7</b>	<b>1</b>	<b>629.0</b>	<b>0</b>	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:**

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
ЗДТГ	1	14,718.0			1	14,718.0						

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

ИТХ	1	11,145.3			1	11,145.3					
ОНХС	3	112,100.0			3	112,100.0	-				
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>137,963.3</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>5</b>	<b>137,963.3</b>	<b>0</b>	<b>-</b>			

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	2	1	1			1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС	4		4					
4	ТТЗ	1	1				1		
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>7</b>	<b>2</b>	<b>5</b>			<b>2</b>		